



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-7</i>
<hr/>	
<i>1.Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудал /2023.10.03-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	<i>4-7</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 10 дугаар
сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр;

Чөлөөтэй: П.Анужин, Х.Баделхан, Б.Бат-Эрдэнэ, С.Батболд.

Нэг.Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудал /2023.10.03-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Ази, Номхон далайн орнуудын газрын захирал Г.Хулан, Консулын газрын захирал Б.Болд, Бодлого, төлөвлөлтийн газрын захирал Г.Бямбасүрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Б.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Зөвшилцөх тухай асуудлын талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн тавьсан асуултад Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг зөвшилцөхийг дэмжиж, Засгийн газарт гарын үсэг зурахыг зөвшөөрье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 14 минут үргэлжилж, 17 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 40 минутад Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсохоор хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 10 цаг 26 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя аа.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирээгүй байна. Пүрэв-Очирын Анужин ирээгүй байна. Ганибалын Амартүвшин ирсэн байна. Хавдесламын Баделхан чөлөөтэй байна, Энхтайваны Бат-Амгалан ирсэн байна, Багаагийн Баттөмөр гишүүн орон нутагт томилолттой байна, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн чөлөөтэй байна, Сүхбаатарын Батболд гишүүн чөлөөтэй байна, Дашдондогийн Ганбат гишүүн ирээгүй байна, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна, Дамдины Цогтбаатар гишүүн гадаад томилолттой байна, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Ирээгүй гишүүддээ хэлээрэй.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Бүгд найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдн яам нээн ажиллуулах тухай Засгийн газрын 2023 оны 10 сарын 3-ны өдөр ирүүлсэн мэдээлэл, зөвшилцөх,

2.Мэдээлэл сонсох Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой асуудлаар мэдээлэл сонсоно хаалттай сонсоно. Ийм 2 асуудлыг хэлэлцэхээр оруулж ирж байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийг гишүүдээ урья.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Нямдоржийн Анхбаяр ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Бямбасүрэн ГХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын захирал, суугаад байгаарай. Г.Хулан Тус яамны Ази, номхон далайн орнуудын газрын захирал. Хулан захирал байна уу? Б.Болд Тус яамны консулын газрын захирал. Б.Нямдаваа Тус яамны төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Нямдагва. Буруу биччихсэн байна шүү.

Төслийн дараа талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Дэлгэрсайхан танилцуулна. Дэлгэрсайхан сайдыг урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 сарын 6-ны өдрийн хуралдаанаар Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байна аа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5.5-д гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.

4.5.8-д улс төр эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа Монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан дипломат төлөөллийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно гэсэн гэж тус тус заасны дагуу Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо Монгол Улсын Элчин сайды яамыг нээн ажиллуулах саналыг боловсруулав.

Тус улстай шууд хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн шийдвэрийн дагуу 1977 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Ерөнхий консулын газар нээн ажиллуулж байсан бөгөөд 2 талын уламжлалт найрсаг харилцаа Төв Азийн бүс нутаг дахь нөлөөг харгалзан 1992 онд Монгол Улс Бүгд найрамдах Узбекистан улстай дипломат харилцаа харилцан тогтоосон гэсэн хэдий ч 1994 онд тухайн Ерөнхий консулын газрыг татан буулгасан. Узбекистаны Самарканд хотноо 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагуудын гишүүн орнуудын Төрийн тэргүүний нарын зөвлөлийн 22 дугаар дээд хэмжээний уулзалт уулзалтад оролцох үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Бүгд найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч Мирзиёев нар 2 улс дипломат төлөөлөгчийн газраа харилцан нээхээр тохиролцсон болно. Гадаад харилцааны сайдын Бүгд Найрамдах Узбекистан улсад 23 оны 3 дугаар сард хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд талууд Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газрын хооронд 2 талт

хамтын ажиллагааны хамтарсан комисс байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. Түүнчлэн 2 талын гадаад харилцааны сайд нарын түвшинд Монгол Улсаас төв Азид чиглэсэн гадаад бодлогыг идэвхжүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсаас Бүгд найрамдах Узбекистан улсад суух Элчин сайдын яамыг Ташкент хотноо нээх тогтвортой нөхцөлийн талаар дэлгэрэнгүй ярилцаж санал солилцсон болно.

Элчин сайдын яамыг 3 орон тоотой ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусгаад байна. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Дэлгэрсайхан сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Сэргэлэн гишүүнээр тасаллаа.

Сэргэлэн гишүүний микрофоныг өгье, асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд танилцуулгатай ч танилцлаа. Энэ бичгээр ирүүлсэн танилцуулга, Дэлгэрсайхан гишүүний танилцуулсан танилцуулга энд бас нэлээд дэлгэрэнгүй юмнуудыг танилцуулсан байх юм. Зүгээр би танин мэдэхүйн чанартай ч гэмээр юм уу нэг юм асуух гэсэн юм. Энэ ажлын хэсгээс.

Энэ Узбекистан улс НҮБ-ын гишүүн улс мөн үү биш үү? Энэ дээр ерөөсөө алга байх юм. Тэгээд цаашидаа та бүхэн анхаараад энэ улс орны танилцуулга хийхээр бол НҮБ-д хэрвээ гишүүн бол гишүүнээр элссэн тухай асуудал, түүнд ямар оролцоотой байдаг талаар бас нэлээд дэлгэрэнгүй танилцуулга хийчихвэл уг нь зүгээр юм уу гэсэн бодол л байдаг юм аа. Тэгээд сая намайг асууж байх явцад

толгой дохихыг бодоход гишүүн гэж ойлголоо.

Тэгэхлээр асуултдаа хариулт авлаа. Гэхдээ би дараа нь үг авахгүйгээр нэгэнт микрофон авсных бас хэлэх үгээ хэлчихье.

Ер нь бол Монгол Улс энэ гадаад улс орнуудтай дэлхийн хамтын нөхөрлөлийн, бусад улс орнуудтай НҮБ-ын гишүүн бусад улс орнуудтай аль болохоор л энэ харилцаа хамтын ажиллагаагаа идэвхжүүлж байх зайлиггүй шаардлагатай. Харилцаа хамтын ажиллагааны хамгийн дээд хэлбэр ямар түвшинд байдаг юм тэр түвшинд хүртэл нь чадвал бүх улс оронтой харилцаагаа хөгжүүлж чадвал Монгол Улсын аюулгүй байдал төдий чинээ хангагддаг ийм зүй тогтолтой.

Ер нь энэ гадаад харилцааны асуудал гэдэг бол та бүхэн ч мэдэж байгаа хамгийн гол асуудал Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ийм л үйл ажиллагаа шүү дээ. Зүгээр бид бол олон төрлөөр ярьдаг, эдийн засагжуулъя, тэгээд л бусад салбаруудын асуудал яриад байдаг. Энэ яриад байгаа энэ олон асуудал чинь эцсийн дүндээ юу вэ гэхлээр Монгол Улсын аюулгүй байдлыг хангах гадаад таатай нөхцөл орчныг бүрдүүлэхийн төлөө манай дипломатууд ГХЯ яг энэ асуудлыг эрхэлсэн төрийн энэ институц ажиллаж байгаа. Тэгээд ийм учраас би энэ аль ч улс оронтой тэр дундаа би НҮБ-ын гишүүн гэж хэлж байгаа нь онцгой анхаарна биз. Нэгдсэн Үндэсний байгууллагын гишүүн улс орнуудтай харилцаа хамтын ажиллагаагаа ямар түвшинд хөгжүүлж болдог юм тэр түвшинд нь тултал хөгжүүлэхийг л цаашидаа манай Гадаад харилцааны яам энэ манай Байнгын хороо гэх мэтчилэн холбогдох албан тушаалтнууд бүтцийн энэ байгууллагууд онцгой анхаарч ажиллаасай гэдэг нэг ийм асуудлыг хэлье гэж бодож байна.

Ер нь бол одоо өнөөдөр дэлхий нийтийн геополитикийн орчин нөхцөл аягүй тийм эмзэг бий болчихлоо.

Одоо та бүхэн сайн мэдэж байгаа байх. Ялангуяа манай ГХЯ-ны хамт олон бол сайн мэдэж байгаа байх. Энэ Израилд болж байгаа үйл явдал Ойрх Дорнодын асуудал. Энэ асуудлаар мэдээж манай энэ асуудлыг хариуцсан байгууллага өөрийн гэсэн бодлого дүгнэлтээ хийчихсэн явж байгаа болов уу гэж би бодож байна. Тэнд оршин сууж байгаа иргэдийнхээ аюулгүй байдлаас эхлээд энэ 2 улсын зөрчилдөөн мөргөлдөөний асуудалд Монгол Улсын төр яаж хандах юм, ямар бодлого баримт батлах юм гэдгээс эхлээд олон асуудлууд өнөөдөр бас л эргэлзээтэй бөгөөд ийм ээдрээтэй, ийм төвөгтэй нөхцөл байдлыг л үүсгэж байгаа шүү дээ.

Тийм учраас та бүхэн энэ гадаад харилцааны асуудал дээрээ аль болохоор нээлттэй олон тулгуурт энэ бодлогоо улам сайн хөгжүүлээрэй.

Б.Энх-Амгалан: Сэргэлэн гишүүн асуулт, санал хамтад нь хэлчихлээ.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Ойлголоо.

Би нэг 3 зүйл хэлье. Та бүхэн тэмдэглээд авчхаарай.

Нэг дэх асуудал, Узбекистан улстай 10.4 сая амдолларын экспорт, импорт, гадаад худалдааны эргэлт байна. Энийг цаашид өсөн нэмэгдүүлэх тал дээр нэлээн онцгой анхаарах ёстой. Ялангуяа энэ дээр бол хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хувьд энэ нутагтай энэ бүс нутагтай хамтран ажиллах маш таатай боломжтой гэж танилцуулга дээр орж ирсэн байна.

Тийм учраас энэ харилцааг өргөжүүлэх, хөгжүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх, гадаад харилцааг эдийн

засагжуулах тал дээрээ нэлээн онцгой анхаарал тавьж энэ дээр ажиллах ёстой шүү гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт нь ер нь манай Гадаад харилцааны яамныхан ачаалал ихтэй байгаа ЭСЯ-дуудынхаа хүмүүсийн тэр нэг цалин пүнлүү тэр нэг амьжиргааны нэг баталгаажих түвшинээс нэг жоохон дээш үнэтэйхэн байх талын юм бодохгүй бол гадаадад байж байгаа Элчин сайдын яамны чинь хүмүүс бол бас л нэлээн хэцүү юм байна лээ шүү дээ. Нэг хүнд аяга кофе аваад өгчих ч мөнгө байхгүй, тэгээд л хөөрхий, гэрээсээ жоохон юм зөөгөөд л ингээд л яваад байдаг тийм ээ.

Тийм учраас энэ дээр ингээд цалингийн юмнуудыг нь жоохон анхаараад тэр хүн амьтан нэг их очдоггүй тэр алс хязгаарт байгаа нь дүүрчээ. Яг тийм ачаалал ихтэй байдаг тэр улсуудтай бол жоохон нэмэхгүй бол болохгүй юм байна лээ шүү. Энийгээ ч бас тэндээ анхаараарай.

Гуравдахь асуудал яг Дундад Азийг чиглэсэн дунд коридор гэж яригдаад байгаа тэр Торгоны замын урсгалыг манайд тээврийн хувьд ч тэр, гадаад худалдааны хувьд ч тэр, транзит тээврийн хувьд ч тэр ашигтайгаар ажиллуулах тал дээр нэлээн онцгой анхаараарай. Ялангуяа сая Туркт ярьж байхад бол Турк, Азербайжан, Казахстаныг дамнасан энэ дунд коридорын чиглэл манайд бол маш их өргөн ач холбогдолтой чиглэл байна лээ шүү.

Тийм учраас бол энэ дээр бол Узбекистантай ярихдаа энэ коридорын чиглэлийг бас анхаарч ажиллаарай гэдгийг хэлье ээ.

Ингээд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна аа.

Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Протоколд Сэргэлэн гишүүнийг дэмжсэнээр аваарай. Сэргэлэн гишүүний төхөөрөмж ажиллаагүй байна.

Уг асуудлыг хэлэлцсэн талаараа талаарх Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийг санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ ээ.

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Хуралдаанд Цогтбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн ирсэн байна.

Дараагийн асуудалдаа оръё дараагийн асуудал хаалттай учраас хаалттай горимд шилжүүлъя ээ.

Ажлын хэсгийн гишүүдээ бас оруулъя.

10.40 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС УРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА